

Ур чадварын дадлагажигч та бүхэнд

Өвлийн улирал ирж хүйтний эрч чангарч эхэллээ.

Ур чадварын дадлагажигч та бүхэн сайн байцгаана уу.

Энэ жил ч мөн адил болон ханиад томуугийн халдвар ихсэх хандлагатай байна. Тиймээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, шинэ оноо эрч хүчээр дүүрэн угтаарай.

Түүнчлэн өвлийн урт амралтаар гэртээ байх хугацаа ихсэж тэр хэмжээгээр цахилгааны төлбөр өндөр гарах талтай байдаг. Тиймээс гадагш гарахдаа цахилгаан халаагуураа асаалттай нь гарахгүй байх зэргээр цахилгаанаа хэмнэхийг зөвлөж байна.

Жилийн эцсийн урт амралттай холбогдуулан доорх зүйлсийг анхааруулж байна.

Уншиж танилцана уу.

1. Өвчний тухай

Ханиад томуу, улирлын шинжтэй ханиад томуунаас урьдчилан сэргийлнэ үү.

- Гаднаас орж ирсэн үедээ болон, хоол идэх үедээ заавал гараа савангаар угааж, хоолойгоо зайлж байх.
- Амьдралын зөв хэмнэлээр амьдарах. (шөнө оройтож унтахгүй байх)
- Хүний биед ашиг тустай тэжээллэг, тэнцвэртэй хоол идэж байх.

2. Зам тээврийн ослын тухай.

Япон улсын замын хөдөлгөөний дүрмийг чандлан баримталж, зам тээврийн осолд орохгүй байхын тулд алхам тутамдаа анхаарал болгоомжтой байцгаарай.

Хэрвээ ямар нэг осол болвол ...

Холбоо барих карт болон түр оршин суух үнэмлэхээ үргэлж биедээ авч явж, гэнэтийн нөхцөл байдалд орсон ч гэсэн тайвнаар хандаж, нийгэмлэг болон хариуцсан төлөөлөгчтэй заавал холбоо бариарай.

Мөн унадаг дугуйны замын хөдөлгөөний дүрмийг сайн баримтлаарай. Замын хөдөлгөөний дүрмийг сайн баримтлана гэдэг нь = өөрийн биеийг хамгаална гэсэн үг.

3. Цагийн ажлын тухай

Ур чадварын дадлагажигч хүн **цагийн ажил болон давхар ажил хийх хориотой** байдаг !

Өөр аж ахуй нэгж, өөр газраас цалин хөлс авах нь өөр ажил хөдөлмөр эрхэлсэнд тооцогдох учир тухайн хүн болон компани нийгэмлэг ч гэсэн **шийтгэл хүлээх болно**. Мөн ур чадварын дадлагажигч нь хууль бус үйл ажиллагаа хийсэнд тооцогдож нутаг буцаах хүртэл арга хэмжээ авна.

4. Газар хөдлөлтийн тухай

Япон улс газар хөдлөлт ихтэй улс гэгддэг. Хэрвээ газар хөдлөлт болвол, юу хийх, ямар арга хэмжээ авах талаар та бүхэн мэдэж байгаа юу. Мөн өөрийгөө хамгаалах үйлдэл хийж чадахуу. Газар хөдлөлттэй холбоотой материал (ахуй амьдралын заавар зөвлөгөөний сурах бичиг болон галын хэрэг эрхлэх газрын гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага (<https://www.bousai.go.jp/kyoiku/gensai/index.html>) зэргийг үзэж, зөв мэдлэгтэй болоорой.

5. Бусад зүйл

Компаний дүрэм, дотуур байрны журам, Япон улсын хууль дүрмийг заавал мөрдөх хэрэгтэй.

Гэмт хэрэг үйлдсэн л бол Япон хүн, гадаад хүн нь хамаагүй ял шийтгэл хүлээх болно. Гэмт хэрэгтэн гэсэн нэр нэг удаа л зүүвэл яаж ч байсан арилахгүй насаараа зүүж явах зүйл гэдгийг анхаарааай.

- Зөвшөөрөлгүйгээр гадуур хонохыг хориглоно. Компани болон нийгэмлэгийн дүрмийг баримталж заавал зөвшөөрөл авах хэрэгтэй.

(Зөвшөөрөл өгөөгүй тохиолдол ч дүрэм журмаа дагах хэрэгтэй)

Та бүхнийг Япон улсад байх хугацаанд аюулгүй амар амгалан байлгах үүднээс гаргасан дүрэм журам юм шүү. Нэг удаагийн хэнэггүй үйлдлээс болж өөрийн хувь тавилан амьдралаа үрэн таран хийх үйлдлийг гаргахгүйн тулд дүрэм журмаа чанд баримтлаарай.

Хулгай хийх, галт тэргэнд туулайчлах, гадаанаас олсон унадаг дугуй унах нь гэмт хэрэгт тооцогдоно ! Хууль буй үйлдэл !

Харамсалтайгаар гадаадын гэмт хэргийн бүлэглэлүүд ур чадварын дадлагажигч нарыг гэмт хэргийн байгаа болгож, гэмт хэрэгт уруу татах явдал ихсэж байна. Нэг нутгийн чинь хүн байсан ч гэсэн амар хялбар яриа, урилганд нь уруу татагдаж болохгүй. Амар сайхан яриа, урилганы цаана унах нүх байгаа шүү. Өөрөө өөрийнхөө амь насыг хамгаалахыг анхааруулая.

Гадаад паспорт, түр оршин суух үнэмлэхээ нийгэмлэг болон

компаниас өөр газар огтхон ч өгч болохгүй!

Цагаачлалын албанаас шууд хурааж авах явдал байхгүй.

Чиний гадаад паспорт, түр оршин суух үнэмлэхийг буруу

зүйлд ашиглах гээд анаж байдгыг санаж анхаарал

болгоомжтой байгаарай !